



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Д. ДЭЛГЭРЦОГТ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.02.20 № 01/01

ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ ТУХАЙ

Үндэсний аудитын газрын 2013 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Эрчим хүчний яамны 2012 оны санхүүгийн тайланд аудит хийлээ.

Эрчим хүчний газраас 2012 онд шилжин ирсэн 265.4 тэрбум төгрөгийн дуусаагүй барилгаас 85,5 тэрбум төгрөгийн барилгыг ТӨХ-ны 2012.02.16-ны 44 тогтоолоор баталсан "Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам" -ын 3.1-д заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчит 20 байгууллагад шилжүүлсэн байна. Гэвч тухайн хүлээн авагч байгууллагад хөрөнгийн зарлагын падаан бичиж өгөөгүй, хүлээн авагч байгууллагатай хөрөнгийг өгсөн актаар тооцоо нийлж акт үйлдээгүйгээс уг хөрөнгө бүртгэлд тусгагдсан эсэх нь тодорхойгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.2-д "санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих" гэж заасныг үндэслэн хөрөнгийг хүлээн авсан байгууллагуудтай тооцоо нийлж актаар баталгаажуулан зөрчлийг арилгаж, гүйцэтгэлийг гарган 2013 оны 7 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг тус яамны Ерөнхий нягтлан бодогч П.Энхцэлмэг, мэргэжилтэн А.Отгонбаяр, Г.Тойрууль нарт даалгав.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
АХЛАХ АУДИТОР



Л.ОДГЭРЭЛ

070001